

ХҮЧ ХЭРЭГЛЭСЭН ГЭМТ ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ганбаатарийн Бямбадорж

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, цагдаагийн эрх зүйн тэнхимийн
багш, докторант, цагдаагийн ахмад

Өнөө үед хууль сахиулах байбүүллага, түний дотор цагдаагийн аайгууллагаас авч хэрэгжүүлж байгаа хүн амыг гэмт хэргээс хохирох үадлаас урьдчилан сэргийлэх ажил нь юуны түрүүнд хүч хэрэглэсэн хүнд, онц хүнд гэмт хэргүүдээс хүн амыг хамгаалахад чиглэсэн уламжлалт, арга хэлбэрээр явагдаж байна.

ЦЕГ-ын статистик тоо судалгаа болон бусад байгууллагуудаас хийсэн судалгааны дүнгээс үзэхэд ноцтой гэмт хэргийн тоо улам үмэгдсээр байгаа нь гэмт хэрэгтнүүдийн дунд явуулсан криминологийн, хохирох эрсдэл өндөртэй хүмүүсийн (potential victims) дунд явуулсан «виктимологийн урьдчилан сэргийлэх ажил хангалттай түвшинд байж чадаагүйг харуулж байна.

Гэмт явдлын өсөлт нь нийгмийн ёс суртахууны доройтол, хууль сахиулах тогтолцооны сул талыг харуулж байгаа ба гэмт хэрэг, хүчирхийллийн тархалтыг зогсоох, архидан согтуурах, мансуурах явдалтай тэмцэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж нийгэмэдийн засаг, улс төр, соёл, ёс зүй, ёс суртахуун, нийгмийн үнэт зүйлсийг сайжруулах талаар яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна¹.

Хууль сахиулах байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлтөд гэмт хэрэгт хохирох эрсдэл өндөртэй иргэдийн үмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настан, хөгжлийн өөрчлөлттэй хүмүүс, буудалдагч, хамгаалагч, биенес эрхлэгч зэрэг дунд зохиох тодорхой зорилго чиглэлтэйгээр урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгт хохирох шалтгаан нөхцөлийг арилгах /антивиктимоген/ талаар тодорхой бус тусгагдсан дутагдал нийтлэг байгаа юм.

Хүмүүсийн амьдралын түвшин, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд суурилсан гэмт явдлын шалтгаанууд нийгэмд оршоор байна.

Хууль сахиулах байгууллагаас зохиох виктимологийн урьдчилан сэргийлэх ажлыг тодорхой чиглэл зорилготой зохион байгуулж, гэмт хэргийн улмаас хохирох явдлыг урьдчилан сэргийлэх тогтолцоо нь дараах зарчмын хандлагад тулгуурлана: Үүнд:

Одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуульд виктимологийн урьдчилан сэргийлэх тухай асуудал илт үгүйлэгдэж байгааг² харгалзаж, гэмт халдлагаас хохирох өндөр эрсдэлтэй хүмүүсийг хамгаалахад зориулсан тусгай бүлэг нэмж оруулах шаардлагатай.

Энэ бүлэгт гэмт хэрэгт хохирч болзошгүй иргэдийн /эмэгтэйчүүд, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өвчтэй болон ганцаар амьдарч байгаа хүмүүс, таксины жолооч, манаач, хамгаалалтын албаны ажилчид, бизнес эрхлэгч, фермерийн эзэд, ченжүүд, түүнчлэн орох оронгүй хүмүүс, биеэ үнэлэгчид, архичид, мансуурагчид, гэмт хэрэгтнүүдийг орогноулагчид/ зэрэг хүмүүст учрах эрсдэлийг багасгахад чиглэсэн виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зааж өгөх. Түүнээс гадна гэмт хэрэгтэн хохирогчидын гүйцэтгэх үүрэг солигдох боломжтой “инверс” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгах боломжтой юм.

Практик амьдрал дээр өөрийн үр ашгаа дээд зэргээр харуулсан цагдаагийн болон хуулийн бусад байгууллагын төрөл албадын хүн хүч, техник хэрэгслийг ашиглах замаар явуулдаг нэгдсэн арга хэмжээнүүдийг зөвхөн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдээс гэмт хэрэг

¹ Малков.В.Д.Криминология учебник. 2011год. 544 стр.

² “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” Монгол Улсын хууль.// Төрийн мэдээлэл. УБ.,1998.№1. 37-р тал

үйлдүүлэхээд урьдчилан сэргийлээд криминологийн урьдчилан сэргийлэх уламжлалт ажил зогсохгүй, мөн гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг багасгахад /виктимологийн урьдчилан сэргийлэх ажил/ чиглүүлэн байнга зохион байгуулах шаардлагатай. Энэ талаар манай замын цагдаагаас явуулж байгаа “Ногоон гэрэл”, “явган зорчигч”, “бүс” гэх зэрэг виктимологийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг дурдаж болно. Мөн хот, суури, х°дөөг холбосон гэмт хэргийг илрүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагаас үр дүнтэй зохион байгуулдаг Илрүүлэлт-оргодол, Эрчимжүүлэлт зэрэг арга нэгдсэн хэмжээнүүдийг дурдаж болно³.

Гэмт хэрэгтэй тэмцэх, хүн амыг гэмт хэрэгд хохирох явдалд эсрэг үйлчлэл үзүүлэх ажлыг сайжруулахын тулд хуулийн байгууллагууд юуны түрүүнд хууль сахиулах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, засгийн газрын агентлаг, орон нутгийн “өр” удирдах байгууллагуудын хамтарсан, тодорхой чиглэл зорилготой нэгдсэн томоохон арга хэмжээнүүдийг хамгийн их сонирхол татаж байгаа гэмт явдалруу чиглүүлэх хэрэгжүүлэх шаардлагатай.

Тухайлбал: Хүч хэрэглэсэн гэмт явдлаас гадна зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийн хүмүүсийн эд мөнгөний гачигдал, хууль зүйн мэдлэггүй байдлыг далимдуулан залилан мэхлэх, гадаадад суралцуулах, ажиллуулах, рекет, луйвар гэх зэрэг зарим төрлийн гэмт хэргийн эсрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь үр дүнтэй байгааг зарим пост социалист орнуудын туршлага харуулж байна. Жишээлбэл: 1999-2000 онд Беларусь улсад “Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх төрийн хөтөлбөр”-ийн хүрээнд улсын прокурор, цагдаагийн байгууллага, нийтийн хэв журам хамгаалалтын, эрүүл мэндийн, орон сууцны яамд хамтран орон нутгийн засаглал, удирдлагын байгууллагатай хамтран ганц бие оршин суугч, өвчтэй архаг архичид, хар тамхичдаас хувьчлагдсан орон сууцаа хууль ёсны дагуу худалдсан эсэхэд үзлэг шалгалт хийх, орон сууц хөлслөгч, эзэмшигчдийг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор тэдний тоо бүртгэлийн тогтолцоог боловсруулах ажлыг зохион байгуулсан туршлагыг хэрэгжүүлж ч болох юм.

Энэ ажлын хүрээнд хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийн талаар иргэд оршин сууч нараас санал авч болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлж тэдгээр хүчирхийлэл үйлдэж болзошгүй этгээдүүдийг хяналтанд авч чадснаар хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн эсрэг үйлдэгдэж болзошгүй олон хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхээс гадна оийм хүчирхийллийн гэмт хэргийн хохирч болохоос хамгаалж чадах боломжтой болно.

Түүнээс гадна хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дараах алхмуудыг хэрэгжүүлж болох юм. Үүнд: Гэр бүл, гэр бүлийн сөрөг хүчин зүйлийг тогтоох, арилгах, дотоодын болон гэр бүлийн зөрчлийг саармагжуулах, тодорхой цагт архины хязгаарлалт тогтоох, хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй болон учруулах аюул заналд цаг тухайд нь хариу арга хэмжээ авах, галт зэвсэг хууль бусаар эзэмших, ашиглах, хадгалах, үйлдвэрлэх буюу галт зэвсэг, байлдааны галт сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг худалдах явдлыг илрүүлэх арга хэмжээ авах, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэх хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт, түүний хэрэгжилтэд бүс нутгийн засаг захиргаанаас байнгын хяналт тавих, хяналтыг сайжруулах зэрэг цогц арга хэмжээг авч болно⁴.

Төрийн бус байгууллагаас хийсэн судалгаанаас үзэхэд хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчид нь гэмт халдлагад эсэргүүцэл бараг үзүүлээгүй дүн гарсан байна. Хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж хоригдсон хоригдлуудын дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд хохирогчдын дөнгөж 12,8% нь тэдний үсрэг эсэргүүцэл үзүүлсэн байна. Энэхүү нөхцөл байдал нь гэмт хэрэгтнүүдээс өөрийн гэмт үйлдлийг шийдвэртэй гүйцэтгэх нөхцөл бүрдсэн байна.

³ Ч.Нямсүрэн. *Аюул буюу эсрэг аюулгүй байдал*, ОА 2005 318. дахь тал

⁴ Малков.В.Д.Криминология учебник. 2011 год. 543 стр.

⁵ Ч.Нямсүрэн *Айюүг дүүдэеи аеёоёиёиёе, ОА* 2005 318. дахь тал

- Бусдын амь насанд халдах, хүнд гэмтэл учруулахдаа хийсэн заналхийлэл нь биелэгдэх үндэслэлтэй бол таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- Хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдсэн хүмүүст оногдуулах ял шийтгэлийг хууль зүйн дагуу шудрага оногдуулах гэх мэт.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүн амын тодорхой бүлгүүдийн дотор зохиох урьдчилан сэргийлэх арга хэмжээ онцгой нөлөөтэй. Тухайлбал: Насанд хүрээгүй хүмүүс ба залуучууд, согтууруулах ундаа хэрэглэгчид, сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийлгэж буй хүмүүс, ажил сургуульгүй хүмүүс, урьд өмнө гэмт хэрэгт шийтгүүлж байсан хүмүүсийн дунд зохиох ажлуудыг хамааруулан үзэж болно.

Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тодорхой хүнийг гэмт хэрэг, зөрчилд оруулахгүй байхын тулд зохиодог нэг бүрчилсэн арга хэмжээ чухал байр эзэлдэг. Хүч хэрэглэсэн гэмт бие хүний объектив талын шинж нь:

- Олон нийтийн хэв журам зөрчиж байсан бөгөөд танхай балмад зан авир нь дахин илрэн гардаг хүмүүс.
- Байнга архидан согтуурагчид буюу мансууруулах бодис хэрэглэгчид
- Ажил сургуульгүй, чөлөөт цагаа ямар ч зорилгогүй өнгөрөөгчид.
- Хүч хэрэглэсэн гэмт хэрэгт өмнө нь шийтгүүлж байсан хүмүүс.
- Зодооны буюу жижиг танхайн хэрэгт захиргааны арга хэмжээ авагдаж байсан хүмүүс
- Биедээ халуун, хүйтэн зэвсэг байнга авч яваа хүмүүс зэрэг болно.

Дээрх шинж байдлыг харгалзан үзэж, хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг гурван ангиллаар хийж болно.

1. Гэр ахуй, ажил сургуулийн нөхцөлд бие хүний зан төлөв бүрэлдэн тогтоход сөргөөр нөлөөлж байгаа нөхцөл байдлуудыг арилгах болон хүмүүжлийн зөв замд оруулах аятай таатай нөхцөлийг бүрдүүлэх;

2. Хүч хэрэглэсэн гэмт хэрэг гарах ахуйн орчин, уур амьсгалыг таслан зогсоох, арилгах;

3. Энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн үйлдэх магадлал бүхий хүнийг олж илрүүлэн түүнтэй тулж ажиллах (мэргэжилгүй хүнийг сургалтанд хамруулах, ажлын байр олоход нь туслах, чөлөөт цагаа зөв боловсон үр ашигтай өнгөрөөхөд нь нөлөөлөх гэх мэт⁶).

Бид хүчирхийллийн гэмт хэргийг урьдчилан сэргийлэхэд дараах алхмуудыг хийх шаардлагатай. Үүнд:

1. Гэр бүлүүдэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлийг тогтоох, түүнийг арилгах,

2. Дотоодын болон гэр бүлийн зөрчлийг саармагжуулах, архины хязгаарлалтыг нэмэгдүүлэх, учруулах аюул заналд цаг тухайд нь хариу арга хэмжээ авах,

3. Хууль бусаар эзэмших, хадгалах, үйлдвэрлэх буюу галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг худалдагч нарыг илрүүлж яллах,

4. Насанд хүрээгүй хүнд зарим хориг тавих тухайлбал: Галт зэвсэг эзэмших тусгай дүрмийг сахиулах,

5. Хүчирхийллийн гэмт хэргийн мөрдөн байцаалтийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх явдлаас сэрэмжилж байнгын хяналт тавих,

6. Дотоод төрөл бүрийн үйлчилгээний газарт хүчирхийллийн гэмт явдлаас сэргийлэх арга хэмжээ авах, хууль эрх зүйн сургалт явуулах, хүн амд боловсрол олгох зэрэг болно⁷.

Хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тухайн улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, хүмүүсийн ёс суртахууны төлөв байдал,

⁶ Б.Батзориг, Г.Эрдэнэбат, Г.Туяа криминологи гарын авлага, УБ 2013.50 дахь тал

⁷ Малков.В.Д.Криминология учебник, 2011год. 544 стр.

шударга ёс хэрхэн хэрэгжиж байгаа зэрэг ерөнхий нөхцөл байдлын шинж чанараас үлэмж хэмжээгээр шалтгаалдаг байна.

Ерөнхий асуудлууд хэрхэн шийдвэрлэгдэж байгаагаас хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн шууд хамаардаг. Ийм ерөнхий зорилтуудын тоонд хүнийг хүнлэг энэрэнгүй үзлээр хүмүүжүүлэх, ёс суртахууны хувьд хүмүүнлэг мэдрэмжтэй байх, хууль зөрчих, хүч хэрэглэн танхай авирлахыг үл тэвчих зэрэг хүмүүжлийн шинж чанарыг эзэмшсэн байх зэргийг багтаан ойлгож болно.

Криминологийн шинжлэх ухааны үүднээс хүчирхийлэх гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиглэлийн дотор дараах нөхцөл байдлуудыг хамааруулан авч үзэж болно.

- Архидан согтуурах явдалтай хийх тэмцлийг төрийн бодлогын түвшинд тавих, согтуурлын хор холбогдлыг шинжлэх ухааны үндэстэй тогтмол сурталчлах, согтууруулах ундаа хэрэглэх, худалдах журмыг хуулиар зохицуулах
- Мансууруулах бодис хэрэглэх, худалдаалах, тараах боломж нөхцөлийг хаах
- Гэр бүлийн болон ахуйн зөрчлөөс үүссэн зөрчил, маргааныг цаг тухайд нь зохицуулах, таслан зогсоох
- Олон нийтийн хэв журмыг гудамж, талбай, нийтийн үйлчилгээний газруудад чанд сахиулах
- Үндэстний болон нутгархах үүднээс үүссэн зөрчлийг цаг тухайд нь арилгах
- Рецидивист болон мэргэжлийн гэмт хэрэгтнүүдээс насанд хүрээгүй хүмүүст нөлөөлөх нөлөөллийг таслан зогсоох
- Насанд хүрээгүй хүмүүс гэр оронгүй, тэраншей, зах, худалдааны төвүүдийг даган амьдрах нөхцөлийг арилгах
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй залуучуудын бүлэглэлийг илрүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, тараах
- Гэмт хэрэг үйлдэхийн тулд эвсэн нэгдсэн, холбоо тогтоосон гэмт бүлэглэлүүдийг илрүүлэх ажлыг идэвхжүүлэх
- Халуун, хүйтэн зэвсгийг хууль бусаар хадгалах, борлуулах, үйлдвэрлэх ажиллагааг илрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх
- Хүчирхийлэх, танхай балмад авирлах үйл ажиллагааг жигшүүлсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр системтэй явуулах
- Бусдын амь насанд халдах хүнд гэмтэл учруулахдаа хийсэн заналхийлэл нь биелэгдэх үндэслэлтэй үед таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Хүч хэрэглэсэн хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст оног-дуулах ял шийтгэлийг хууль зүйн дагуу шударга оногдуулах гэх мэт.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүн амын тодорхой бүлгүүдийн дотор зохиох урьдчилан сэргийлэх ажил онцгой нөлөөтэй гэж үзэж болно. Тухайлбал: Насанд хүрээгүй хүмүүс ба залуучууд, согтууруулах ундаа хэрэглэгчид, мансууруулах бодис хэрэглэгч буюу сэтгэл мэдрэлийн эмчилгээ хийлгэж буй хүмүүс, ажил сургуульгүй хүмүүс, урьд өмнө гэмт хэрэгт шийтгүүлж байсан хүмүүсийн дунд зохиох ажлуудыг хамааруулан үзэж болно.

Хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй тэмцэх тусгай арга хэмжээг дотор нь ерөнхий, бүлэглэсэн, нэг бүрчилсэн арга хэмжээ гэж ангилан үзэж болно.

Энэхүү тусгай арга хэмжээний доторхи ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахтай холбоотой ажлууд тухайлбал хүч хэрэглэсэн ба танхайн төрлийн гэмт хэргийн гаралтын түвшин, бүтэц, хөдөлгөөнийг судлах, мэдээлэх, криминологийн прогноз хийх, урьдчилан сэргийлэх ажилд үнэлэлт өгөх, тодорхой нутаг дэвсгэрт хийх ажлын криминологийн төлөвлөгөө зохиох зэрэг ажлууд хамаарагдана.

Хүч хэрэглэсэн гэмт хэрэгтэй явуулах тэмцэлд бүлэглэсэн буюу нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ онцгой ач холбогдолтой. Эдгээрийн объект нь нийгэмд харш зан төлөв төлөвшсөн хүч хэрэглэсэн гэмт хэрэг үйлдэх өндөр магадлалтай бие хүмүүс байна. Ийм хүмүүсийн объектив талын шинж нь:

- Олон нийтийн хэв журам зөрчиж байсан бөгөөд танхай балмад зан авир нь дахин дахин гардаг хүмүүс
- Ажил сургуульгүй, чөлөө заваа ямар ч зорилгогүй өнгөрөөгчид
- Хүч хэрэглэсэн гэмт хэрэгт өмнө нь шийтгүүлж байсан хүмүүс
- Зодооны буюу жижиг танхайн хэрэгт захиргааны арга хэмжээ авагдаж байсан хүмүүс
- Биедээ халуун хүйтэн зэвсэг авч яваа хүмүүс зэргийг багтаан нэрлэж болно.

Хүчирхийллийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд Виктимологийн боловсролыг дараах чиглэлээр зохион байгуулах шаардлагатай. Үүнд:

1. Хүч хэрэглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээний үндсэн шинж нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүнийг танин олж түүнтэй тулж ажиллах буюу тодорхой үйлдэл дээр нь таслан зогсооход оршдог. Ийм учраас энэ арга хэмжээ нь хэрэгжүүлэхэд төвөгтэй хэдий ч хамгийн үр нөлөөтэй буюу үр дүн нь шууд гардгаараа онцлог юм⁸.

Хүн амаас гэмт хэрэгт хохирох арга замуудын тухай, гэмт хэргийн хохирогч болсон этгээдүүдийн тухай мэдээллийг ашиглаж түүнээс урьдчилан сэргийлэх аргын тухай мэдээллүүд. Энэ чиглэлийн агуулга нь хохирч болох эрсдэлийг багасгах, бууруулах талаарх заавар, зөвлөмж, санамж; сергөлдөөнийг шийдвэрлэх арга зам, хэрэгслийн тухай мэдээлэл; хамгийн ихээр гэмт хэрэгт хохирч болзошгүй байр, газрын тухай мэдээ зэрэг байж болно.

2. Үзүүлэн таниулах, ухуулах ажлын боломжийг ашиглах: аль нэгэн гэмт хэргийн хохирогч болохоос зайлсхийх тухай зөвлөгөөг агуулсан хуудас, санамж, зурагт хуудас гэх зэрэг.

3. Аргагүй хамгаалалтын мөн чанарын тухай, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт халдлагыг таслан зогсооход түүний ач холбогдлыг иргэдэд лекц, ярилцлагаар тайлбарлан таниулах.

4. Илэрсэн гэмт хэргийн тухай, гэмт этгээдэд ногдуулсан ялын дөрөл, хугацааны тухай мэдээллүүд. Хүний эрх, эрх чөлөөний баталгаа, шөнийн манаачийн хувьд нь төрийн нэр хүндийг дээшлүүлэх зорилгоор гэмт явдлын үр дагаврыг нээн үзүүлэх.

5. Ерөнхий боловсролын болон коллеж, их, дээд сургуулиудад виктимологийн хичээлийг сургалтын программд оруулах. Тэр ч байтугай хүүхдийн цэцэрлэгт виктимологийн анхдагч зааварчлагыг авах боломжоор хангах. Их дээд, ерөнхий боловсролын сургуулиудад зөвхөн виктимологийн лекцийг уншаад зогсохгүй, нэгбүрчилсэн хамгаалах хэрэгслийг эзэмших аргачлалыг заах.

Хүчирхийллийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд зохион байгуулалтын талаар дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд

1. Гэмт явдалтай тэмцэх төрийн санг нэн яаралтай байгуулж, түүний хөрөнгийг гэмт хэргийн хохирогчид туслах зорилгоор ашиглах.

2. Гэмт хэргийн тухай, түүнийг хэрхэн авч хэлэлцсэн үр дүн, гэмт хэргийн хохирогчдын /бодит (actual victims) буюу нууц (latent victims)/ тухай мэдээлэх, зарлах төрийн бус тоо бүртгэлийг бий болгох.

3. Виктимологийн асуудлуудыг судлах тусгай байгууллага, алба байгуулах, мөн виктимологийн мэргэжилтнийг бэлтгэж эхлэх.

⁸ Б.Батзориг, Г.Эрдэнэбат, Г.Туяа криминологи гарын авлага, УБ 2013. 51 дахь тал

4.Янз бүрийн байгууллага албан газруудад /хуулийн байгууллагууд, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, байгууллага, албан газар гэх зэрэг/ мэргэжлийн виктимологчын орон тоог бий болгох. Ялангуяа дунд сургуулийн нийгмийн ажилтанг виктимологч болгох шаардлагатай байна.

Энэ байдлаас үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн объект зөвхөн гэмт хэрэг үйлдсэн этгээд биш, мөн гэмт хэргийн хохирогч учраас гэмт хэрэгт хохирох явдлаас урьдчилан сэргийлэх ажил нь гэмт явдалд иж бүрнээр нөлөөлөх, гэмт хэргийг урьдчилан сэргийлэх зорилгыг шийдвэрлэх чухал арга хэрэгсэл нөхцөл мөн.